



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 725

Улаанбаатар хот

“Зүүнбаян төмөр зам” хязгаарлагдмал
хариуцлагатай компанийн талаар авах
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 434 дүгээр тогтоол, “Зүүнбаян төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зүүнбаян төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид нэгтгэсүгэй.
2. “Зүүнбаян төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид нэгтгэх гэрээг хавсралт ёсоор баталсугай.
3. Компани нэгтгэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү), Гүйцэтгэх захирал (П.Ганхүү) нарт тус тус даалгасугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн
75 дугаар тогтоолын хавсралт



КОМПАНИ НЭГТГЭХ ГЭРЭЭ

2022 оны ... дугаар сарын ... өдөр

Улаанбаатар хот

№:

Энэхүү Компани нэгтгэх гэрээг (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “Монголын төмөр зам” ТӨХК (цаашид “МТЗ” ТӨХК гэх)-ийг төлөөлж, нөгөө талаас “Зүүнбаян төмөр зам” ХХК (цаашид “ЗТЗ” ХХК гэх)-ийг төлөөлж (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай” 434 дүгээр тогтоол, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн хурлын ... дугаар тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн дугаар тогтоол, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн хурлын ... дугаар тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн дугаар тогтоолыг тус тус үндэслэн дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 434 дүгээр тогтоолын дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг “МТЗ” ТӨХК-д шилжүүлэх замаар нэгтгэн зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, зохицуулахад оршино.

Хоёр. Үндсэн нөхцөл

2.1. Энэхүү гэрээг байгуулснаар “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн бүх эрх, үүрэг, хариуцлага 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн “МТЗ” ТӨХК-д бүрэн шилжинэ.

2.2. Талуудын Хувьцаа эзэмшигчийн шийдвэр болон энэхүү гэрээг үндэслэн “Зүүнбаян төмөр зам” ХХК нь дараах эрх, үүрэг, хариуцлагыг эд хөрөнгийн хамтаар “Монголын төмөр зам” ТӨХК-д шилжүүлэх ажиллагааг талууд хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. “ЗТЗ” ХХК-ийн хөрөнгө, түүнд хамаарах эрх, үүрэг, хариуцлага;

2.2.2. “ЗТЗ” ХХК-ийн эзэмшиж буй эрх, тусгай зөвшөөрөл, шаардах эрх,

2.2.3. “ЗТЗ” ХХК-д хууль, гэрээний дагуу олгогдсон эрх, хүлээх үүрэг, хариуцлага;

Гурав. Нэгтгэх үйл ажиллагаа

3.1. “Зүүнбаян төмөр зам” ХХК нь 10,000,000 /арван сая/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд энэхүү хөрөнгөө мөнгөн хөрөнгөд хөрвүүлэн “МТЗ” ТӨХК-д шилжүүлнэ.

3.2. Компанийг нэгтгэснээр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орохгүй болно.

3.3. Талууд нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулах комисс байгуулж, дараах үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлнэ.

3.3.1. “ЗТЗ” ХХК-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны болон ажлын байр хадгалагдаж байгаа ажилтны судалгаа гаргаж, “МТЗ” ТӨХК-д ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах;

3.3.2. “ЗТЗ” ХХК-ийн эд хөрөнгийн тооллого хийж, бодит байдал чанарыг зураг, дүрс бичлэгээр бэхжүүлэн акт үйлдэж хүлээлцэх;

3.3.3. “ЗТЗ” ХХК-ийн байгуулсан гэрээ, хэлцлийн баримт бичгийг бүртгэлийн дагуу баримтаар хүлээлцэж, гэрээний эрх, үүрэг, хариуцлагыг үргэлжлүүлэх, тооцоо нийлэх, гэрээний харилцааг дуусгавар болгох, гэрээ дүгнэх асуудлыг шийдвэрлэх;

3.3.4. “ЗТЗ” ХХК-ийн дансанд байгаа мөнгөн хөрөнгийг “МТЗ” ТӨХК-ийн дансанд шилжүүлж, баримтыг хүлээлцэх;

3.3.5. Архивын баримт бичиг, бусад баримт бичгийг Архивын тухай хууль, байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу цаасан болон цахим суурьтайгаар баримт үйлдэж, хүлээлцэх;

3.3.6. “ЗТЗ” ХХК-ийн нууцад хамаарах мэдээлэл, баримт бичгийг хүлээлцэх ажлыг талуудын нууц хариуцсан албан тушаалтнуудын хооронд зохион байгуулах.

Дөрөв. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эрх, үүрэг

4.1. Энэхүү гэрээний дагуу “МТЗ” ТӨХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

4.2. Засгийн газрын 2022 оны 434 дүгээр тогтоол болон энэхүү гэрээний дагуу “ЗТЗ” ХХК-ийн эрх, үүрэг, үйл ажиллагааг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн “МТЗ” ТӨХК хэрэгжүүлнэ.

4.3. Хөрөнгийг акт үйлдэж шилжүүлэн авсны дараа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулна.

4.4. “ЗТЗ” ХХК-д 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтнуудыг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн “МТЗ” ТӨХК нь хууль тогтоомжийн хүрээнд ажлын байраар хангана.

4.5. Хөдөлмөрийн гэрээ шинэчлэн байгуулахтай холбоотой харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу зохион байгуулна.

4.6. “ЗТЗ” ХХК-д 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаагаас бусад этгээдийг ажлын байраар хангах үүрэг хүлээхгүй.

4.7. “ЗТЗ” ХХК-ийн архив, санхүүгийн тайлан, хөндлөнгийн хяналт шалгалтыг дуусгаж, баримт материалын “МТЗ” ТӨХК-д бүрэн хүлээлгэн өгөх хүртэл “ЗТЗ” ХХК-ийн холбогдох ажилтнуудыг гэрээгээр ажиллуулах.

4.8. Компанийг нэгтгэхтэй холбоотойгоор хуульд заасан бусад шаардлагатай ажиллагааг хийнэ.

Тав. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн эрх, үүрэг

5.1. “ЗТЗ” ХХК нь нэгтгэлийн өмнөх хаалтын санхүүгийн тайлан, балансыг гаргаж, баталгаажуулна.

5.2. “ЗТЗ” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй нийт хөрөнгийг “МТЗ” ТӨХК-д шилжүүлэх ажлыг хамтран гүйцэтгэнэ.

5.3. Хөлсөөр ажиллах гэрээ болон бусад гэрээг дуусгавар болгох, тооцоо нийлэх, цуцлах арга хэмжээг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд авч хэрэгжүүлнэ.

5.4. Албан татвар, төлбөр, хураамжийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор төлөх арга хэмжээ авч, баримтыг МТЗ ТӨХК-д хүлээлгэн өгнө.

5.5. “ЗТЗ” ХХК нь өөрийн өглөг ба авлагын тооцоог 2022 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр тасалбар болгон харилцагч нартай хийж, тулган баталгаажуулж, гэрээг “МТЗ” ТӨХК-тай шинэчлэн байгуулах мэдэгдлийг хүргүүлнэ.

5.6. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 434 дүгээр тогтоол гарсантай холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д зааснаар ажилтанд олгох дор дурдсан тэтгэмжийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор зохион байгуулна.

5.6.1. 1-6 хүртэл сар ажилласан бол 1 сар;

5.6.2. 6-12 хүртэл сар ажилласан бол 2 сар;

5.6.3. 13 сараас дээш бол 3 сарын тэтгэмж олгож, баримтыг “МТЗ” ТӨХК-д хүлээлгэн өгнө.

5.7. “ЗТЗ” ХХК-ийн нийт ажилчдын ажилласан хугацааны ээлжийн амралтын тооцоог 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгоно.

5.8. “ЗТЗ” ХХК нь 2021, 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад ороогүй үүссэн баримт бичгийг жагсаалтаар “МТЗ” ТӨХК-д хүлээлгэн өгнө.

5.9. Компанийг нэгтгэх гэрээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

5.10. Компанийг нэгтгэхтэй холбоотойгоор бусад шаардлагатай ажиллагааг хийнэ.

5.11. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу байгууллагад үүссэн баримт бичгийг архивын боть болгож, шилжүүлэхэд бэлтгэх ажлыг журмын дагуу зохион байгуулах.

Зургаа. Нэгтгэх үйл ажиллагааг дуусгах

6.1. Нэгтгэсэн компанийг татан буулгаж, Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр дуусгавар болно.

6.2. Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу компанийг өөрчлөн байгуулах үйл ажиллагаа дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор дараах мэдэгдлийг “МТЗ” ТӨХК холбогдох этгээдэд албан бичгээр хүргүүлнэ. Үүнд:

6.2.1. Компани өөрчлөн байгуулагдсан тухай /он, сар, өдөр, өөрчлөн байгуулсан арга, хэлбэр, шийдвэр/;

6.2.2. Компанийг нэгтгэсний улмаас компанийн нэр, хаяг, байршил, санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт;

6.2.2. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн харилцагчдын өмнө хүлээх эрх, үүрэг, “Монголын төмөр зам” ТӨХК-д шилжсэн тухай.

Долоо. Хариуцлага

7.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг зохих ёсоор хариуцлагатай биелүүлэх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хор уршгийг буруутай тал эсхүл буруутай этгээд хариуцаж арилгана.

7.2. Компани нэгтгэх үйл явцад ирээдүйд эрсдэл учруулах, гуравдагч этгээдэд шаардах эрх үүсгэх аливаа үйлдэл хийх, үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.

7.3. Талууд энэхүү гэрээ болон бусад баримт бичиг, компанийг нэгтгэх явцад олж мэдсэн мэдээллийг задруулахыг хориглоно.

Найм. Бусад зүйл

8.1. Энэхүү гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэх бөгөөд гэрээний хувь тус бүр хууль эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.

8.3. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**НЭГТГЭЖ БУЙ КОМПАНИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал

**НЭГДЭЖ БУЙ КОМПАНИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“ЗҮҮНБАЯН ТӨМӨР ЗАМ” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал